

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АРВАНГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны дөрөвдүгээр сарын 14-ний 14 цаг 05 минутад эхэлж, 16 цаг 15 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Сангийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Төрийн өмчийн удирдлага, бүртгэл, тооллого, хяналтын газрын даргын албан тушаалд томилуулахаар- Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар- Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 06 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Бэгзсүрэнгийн Шинэбаатарыг Сангийн яамны Төрийн өмчийн удирдлага, бүртгэл, тооллого, хяналтын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 07 дугаар</p>

		<p>дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Батхүүгийн Ганбатыг Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 08 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Шаривын Жандосыг Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Архангай аймаг дахь салбар зөвлөлийн даргын 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 37 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн</p>

		<p>захиргаа, удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн Эрдэнэцогтын Гончигдамбааг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилсугай.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 1-ийн “нарийн бичгийн дарга - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн Эрдэнэсайханы Эрдэнэбаяр” гэсэн хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 67 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Э.Гончигдамбаад үүрэг болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах Үүнд:</p> <p>1) Төрийн нарийн бичгийн дарга /Салбар зөвлөлийн дарга/ 2) Төрийн захиргааны</p>

		<p>удирдлагын газрын дарга</p> <p>3) Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга</p> <p>4) Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</p> <p>5) Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,</p> <p>6) Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга</p> <p>7) Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн албаны дарга,</p> <p>8) Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга,</p> <p>9) Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дарга,</p> <p>10) Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга,</p> <p>11) Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн менежмент хариуцсан мэргэжилтэн /Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга/</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 13 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Төв, Орхон, Баянхонгор аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2016 оны 03 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 07-ны өдрүүдэд Төв аймаг, Баянхонгор аймаг, Орхон аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн

албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 14 -ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 38 иргэн /Баянхонгор аймагт 33, Орхон аймагт 5/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3, 4, 5 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 49 иргэн /Төв аймагт 21, Баянхонгор аймагт 12, Орхон аймагт 16/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 6, 7 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 /Баянхонгор аймагт 6, Орхон аймагт 2/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 8, 9, 10 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 18 иргэн /Төв аймагт 6, Баянхонгор аймагт 10, Орхон аймагт 2/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх

3. Энэхүү тогтоолын 6-10 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 26 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөл /Д.Нямдорж/-д, Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь

		салбар зөвлөл /О.Тойвгоо/-д, Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлд тус тус үүрэг болгох 4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.
5	Цагааннуурын чөлөөт бүсийн захирагчийн албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай зарлах тухай	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатын 2016 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 01/1012 тоот албан бичгээр Цагааннуурын чөлөөт бүсийн захирагчийн албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2016 оны 5 дугаар сарын 10-нд зохион байгуулахаар шийдвэрлэв.
6	"Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшил, үр дүн" сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн сонголт сонсож хэлэлцэх	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.4 дэх заалтыг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах талаар өгч буй зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнг 2016 оны 10 дугаар сарын 01-ний дотор тайлагнахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Г.Нарангэрэлд даалгах 2. Энэхүү тогтоол, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга

		С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА